



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/26

Номгон

Г Хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8, 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багийн “Гийхнаран” хорооллын цэвэр усны худаг эвдэрч 32 айл өрх, халаалтын зуух усгүй болж шинээр худаг гаргах шаардлагатай болсон тул Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багийн Гийхнаран хорооллын айл өрхийг ундны усаар, Баянхонгор Чандмань ХК-ний дулааны зуухыг хэрэгцээний усаар хангах ажлын холболт, тоноглол хийх ажилд хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгөд шаардагдах зардал 9.900,000 (есөн сая есөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА  Г.ЭНХБАЯР